

ОЛОН УЛСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТНИЙ IV ИХ ХУРАЛ

Олон улсын монголч эрдэмтний (ОМУЭ) ээлжит дөрөвдүгээр их хурал 1982 оны 8-р сарын 24-28 нд Улаанбаатарт боллоо.

БНМАУ-ын Шинжлэх ухааны Академийн ерөнхийлөгч, академич Ч.Цэрэн их хурлын бүгд хуралдааныг нээж хэлсэн үгэндээ олон улсын монголч эрдэмтдийн үйл ажиллагаа, монголын судлалд тэдний оруулсан хувь нэмрийг дурдаад БНМАУ-ын монгол судлал нь өнө эртний уугуул нутагтаа шинэ нийгмийг цогцлон байгуулж байгаа монголын ард түмний бүтээлч хөдөлмөр, эх орны шинжлэх ухааны салшгүй хэсэг мөнийг онцлон тэмдэглэв. Их хуралд Англи, АНУ, Афганистан, Бельги, Болгар БНАГУ, Вьетнам, ЗСБНХУ, Итали, Канад, Норвеги, Польш, Румын, Турк, Унгар, Финланд, Франц, ХБНГУ, Чехословак, Швед, Энэтхэг Япон зэрэг 23 орон, ЮНЕСКО, Олон улсын Алтай судлалын бага хурал, Санскрит судлалын олон улсын холбоо, Төв Азийн иргэншлийг судлах олон улсын нийгэмлэг зэрэг эрдэм шинжилгээний байгууллагууд төлөөлөгчдөө томилон оролцуулжээ.

Ерөнхийлөгч Ч.Цэрэн эдгээр төлөөлөгч, зочдод баяр хүргээд ОУМЭ-ийн IV их хуралд анхаарал тавьж дэмжлэг үзүүлсэн ЮНЕСКО-гийн удирдлагад халуун талархал илэрхийлэв.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, БНМАУ-ын ШУА-ийн хүндэт гишүүн нөхөр Юмжаагийн Цэдэнбалаас ирүүлсэн баярын илгээлтийг хуралд оролцогсод халуун дотноор хүлээж авлаа.

Бүгд хуралдаанаар их хурлын нарийн бичгийн дарга нарын газар, салбар хуралдааны дарга нарыг томилсны дараа ШУА-ийн дэд ерөнхийлөгч, академич Ш.Нацагдорж «Монгол судлалын тулгамдсан асуудал» гэсэн илтгэл тавилаа.

Нөхөр Ш.Нацагдорж илтгэлдээ: Монголын ард түмний социализмын материал техникийн бааз байгуулахад олсон ололт амжилтын үндсэн дээр манай шинжлэх ухаан, түүний дотор монгол судлал амжилттай хөгжиж ирснийг тэмдэглээд дэлхийд хэмжээний монгол судлалын талаар ярихдаа ЗХУ дахь дорно дахины судлалын ухааны хамгийн эртний салбарын нэг болох монгол судлал бол олон чиглэлээр дэлхий дээр тэргүүний байр эзэлж байсан ба эзэлсээр байна. Зөвлөлтийн эрдэмтэд марксист-ленинист арга зүйд тулгуурлан мэргэжил нэгт монгол нөхөдтэйгээ хамтран ажиллаж монгол судлалын уламжлалт болон шинэ чиглэлүүдийг цаашид хөгжүүлэх талаар сайхан амжилт олсоор байна гэж тэмдэглэв. Илтгэгч Европын социалист орнууд дахь монгол судлалын хөгжлийн үндсэн шинж гэвэл тэд өвөрмөц онцлог бүхий үндэсний монгол судлалын сургуультай болж байгаа явдал гээд БНСВУ анхны монгол судлаачидтай болсон, хөгжиж байгаа орнуудаас Энэтхэг улсад (монгол судлал биеэ даасан шинжлэх ухаан болон гарч ирж байна гэж тэмдэглэв.

Сүүлийн 20 жилд капиталист орнуудын монгол судлаачид Монголын дундад ба шинэ үеийн түүх, нүүдэллэх ёсны ерөнхий асуудлыг судлах талаар нилээд ажил хийсэн боловч тэд манай орны өнгөрсөн түүх, орчин үеийн социалист монголын үнэн байдлыг гажуудуулан гуйвуулж, түүний

нийгэм эдийн засаг, соёлын ололт амжилтад эргэлзэж, улс төрийн биеэ даасан бодлогыг муучлан бичсэн ном зохиол зарим капиталист оронд хэвлэгдэн гарч байгаа тухай дурдав.

Дэлхийн монгол судлалд БНМАУ-ын гүйцэтгэж байгаа роль улам өсч байгаа явдал монголын тухай шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чухал үйл явдал болсныг илтгэгч цохон тэмдэглээд монгол судлалыг цаашид хөгжүүлэх үүднээс монгол судлагчдын Олон улсын их хурлын байнгын хорооны үйл ажиллагааг улам хүчтэй болгон идэвхжүүлэх талаар тодор- хой санал тавилаа..

ОУМЭ-ний IV их хурлын «түүх, эдийн засаг», «хэл, утга зохиол», «соёл урлаг, философи» гэсэн салбар хуралдаанаар нийт хоёр зуу гаруй илтгэл хэлэлцэв .

«БНМАУ-ын капиталист бус хөгжлийн зарим чухал асуудал» сэдвээр ШУА-ийн сурвалжлагч гишүүн С. Норовсамбуугийн тавьсан илтгэл олон улсын монголч эрдэмтдийн анхаарлыг татав. Капиталист бус хөгжлийн замын зарим чухал нийтлэг ач холбогдол бүхий талын мөн чанар нь нэгдүгээрт, капиталист бус хөгжлийн замын үйл явц нь гэнэт агшин зуур хэрэгждэг зүйл биш харин зайлшгүй шаардагдах олон тооны нөхцөл бүрэлдэж ирсний үр дагавар мөн болоход оршино, хоёрдугаарт, капиталист бус хөгжлийн үйл явц нь социализмд хүрэх зорилгуудыг сайтар шийдвэрлэх учраас засгийн эрхийг хөдөлмөрчин ард түмэн гартаа авах явдлаар эхэлдэг, гуравдугаарт, капиталист бус замаар амжилттай хөгжих нөхцөл бол ах дүү социалист хамтын нөхөрлөлийн орнууд, юуны урьд социализм, коммунизмын замыг тэргүүлэн тавигч ЗХУ-тай тогтоосон найрамдал бөгөөд дөрөвдүгээрт, олон түмнийг хувьсгалт тэмцэлд дайчилж, бүх дэвшилт хүчийг нэгтгэн капиталист бус замын стратеги тактикийг тодорхойлдог марксист-ленинист нам бэлэн байх явдал бол энэ замын үндсэн нөхцөл болдог эдгээрийг БНМАУ-ын туршлага, хөгжлийн түүхэн баримтуудаар нотлон ярилаа.

«Түүх, эдийн засаг» салбарт «хөдөө аж ахуйг хоршоолж капиталист бус замаар хөгжсөн БНМАУ-ын түүхэн туршлага» сэдвээр БНПАУ-ын монголч эрдэмтэн Генрик Холой сонирхолтой илтгэл тавилаа.

«Хэл, утга зохиолын» салбар хуралдаан дээр «ЗСБНХУ-д монголын утга зохиолыг судалж байгаа нь (1977-1982)» сэдвээр илтгэсэн хэлбичгийн ухааны дэд эрдэмтэн К.Н.Яцковская зөвлөлтийн монголч эрдэмтдийн оролцоотойгоор ЗСБНХУ-ын хэвлэлийн томоохон газрууд «Монголын утга зохиолын номын сан» гэдэг 15 боть ном хэвлэхээр бэлт- гээд эхний гурвыг нь хэвлэв. «Социалист орнууд дахь утга зохиолын шүүмжлэл» цувралаар «Шинэ төлөв» гэдэг ном гарав гэж мэдэгдээд эдгээр ном хэвлэл бол монголын соёлын хөгжилтийн төдийгүй, нийт хүн төрөлхтний соёл иргэншлийн хөгжилтэй хамааралтай болохыг онцлон тэмдэглэв. Энэ салбар хуралдаанд японы монголч эрдэмтэн Т.Мацуяа манай их зохиолч Д.Нацагдоржийн «Миний нутаг», АНУ-ын профессор Л.Мозес «Монголын нууц товчооны домгийн зүйлс» сэдвээр тус тус илтгэл тавьж эрдэм шинжилгээний сонирхолтой дүгнэлт хийв. Энэчилэн манай улсын түүх эдийн засаг, хэл утга зохиол, философи, соёл урлагийг судлаач олон орны монголч эрдэмтэд энэхүү чуулга уулзалтынхаа үеэр судалгаа шинжилгээнийхээ ажлын дүнгээс харилцан ярилцаж монгол судлалыг өргөжүүлэн баяжуулахад нэмэр хандив орууллаа.

Монгол судлалыг нийт Дорнодахины судлалын системд өргөн хүрээтэй тавихын нийгэм-эрдэм шинжилгээний ач холбогдлыг зөвлөлтийн эрдэмтэд онцлон дэвшүүллээ. Японы эрдэмтэн Ш.Озава хэлэхдээ: «Улаанбаатар хот дэлхийн монгол судлалын төв болж монголч эрдэмтний их хурал олон орны монголч эрдэмтдийн уулзаж танилцах, саналаа солилцох

гол индэр болжээ. Үүнээс хойш ч олон улсын монгол судлалын гол төв нь Улаанбаатар хэвээр байх бөгөөд цаашдаа ч улам олон орны эрдэмтдийг монгол судлалд татан оролцуулах төв болно гэдэгт би итгэж байна» гэжээ. Энэ бол их хуралд оролцогчдын нийтлэг санааны илрэл болов.

Олон улсын монголч эрдэмтний IV их хурлын төгсгөлийн бүгд хуралдаан дээр «ОУМЭ-ний IV их хуралд оролцогчдын мэдэгдэл»-ийг профессор Жек Легран (франц) уншиж, дэлхийн цөмийн сүйрлийн аюулыг сэрэмжлэн зайлуулж, хүн төрөлхтний соёл иргэншлийг аврахын төлөө, энх тайван хамтын ажиллагааны төлөө зориг эрмэлзэл төгс байгааг ОУМЭ-ний IV хуралд оролцогч монголч эрдэмтдийн өмнөөс илэрхийлэхэд хуралдагсад алга ташин хүлээж авлаа.

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга, БНМАУ-ын ШУА-ийн хүндэт гишүүн, доктор Юмжаагийн Цэдэнбалд ОУМЭ-ий IV их хуралд оролцогчдоос өргөх илгээлтийг ОУМЭ-ний их хурлын байнгын хорооны дэд ерөнхийлөгч профессор О. Латтимор (АНУ) уншихад хуралдагчид алга нижигнүүлэн ташиж талархан дэмжлээ.

Их хурлын төгсгөлийн бүгд хуралдаан дээр М.Сингх (ЮНЕСКО), Д.Синор (Алтайн судлалын ерөнхий бага хурал), П.Фитце (БНАГУ), Т.Текин (Турк), С.И.Потапенко (Төв Азийн иргэншлийн судлалын төв) нарын зэрэг хүмүүс үг хэлсний дотор ЗСБНХУ-ын ШУА-ийн Дорнодахиныг судлах хүрээлэнгийн орлогч захирал, профессор В.М.Солнцев хэлэхдээ: «тус их хурлын шинжлэх ухааны ач холбогдол асар их юм. Их хурлын материал нь шинжлэх ухааны олон нутгийн зүгээс том үнэлэлт авч, монгол судлалын цаашдын хөгжилд том хувь нэмэр болно» гэж цохон тэмдэглэв.

ОУМЭ-ний IV их хуралд гадаад дотоодын 200 гаруй эрдэмтэд оролцож 200 гаруй илтгэл тавьж хэлэлцүүлсэн ба толилуулсаныг 1959 онд хуралдсан анхдугаар их хурлаар 15 орны 40 гаруй эрдэмтэд хуралдаж 34 илтгэл хэлэлцэж байсан үетэй харьцуулж үзэхэд ОУМЭ-ний их хурал, монголч эрдэмтдийн судалгааны цар хүрээ асар нэмэгдсэнийг харуулж байна.

БНМАУ-ын ШУА-ийн ерөнхийлөгч Ч.Цэрэн ОУМЭ-ний IV их хурлыг хааж хэлсэн үгэндээ, тус их хурал монгол судлалын тулгамдсан асуудлыг хамтын хүчээр гүнзгийрүүлэн судлах, олон улсын монгол судлалыг цаашид хөгжүүлэх болон улс түмний энх тайвны үйл хэргийн тусын тулд янз бүрийн орны монголч эрдэмтдийн эрдэм шинжилгээний бүтээлч ажиллагааг өргөжүүлэхэд хувь нэмэр болсныг тэмдэглэхэд таатай байна гэж дүгнэв.

Тус их хурал зохион байгуулалтын асуудал хэлэлцэж ОУМЭ-ний их хурлын байнгын хорооны бүрэлдэхүүнд зарим өөрчлөлт оруулж ОУМЭ-ний байнгын хорооны ерөнхийлөгчөөр академич Ч.Цэрэн (БНМАУ), дэд ерөнхийлөгчөөр профессор Д.Дылыков (ЗСБНХУ), профессор О.Латтимор (АНУ), академич Л.Лигети (БНУАУ), академич Ш.Нацагдорж (БНМАУ), профессор В.М.Солнцев (ЗСБНХУ), профессор П.Фитце (БНАГУ), профессор В.Хайссиг (ХБНГУ), профессор Ш.Хаттори (Япон), ерөнхий нарийн бичгийн даргаар доктор С.Лувсанвандан (БНМАУ) нарыг батлав.

Э. Пунцаг